

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНД ДЭЛХИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХЯМРАЛЫН НӨЛӨӨЛӨЛ, ТУЛГАМДСАН АСУУДЛУУД, ШИЙДВЭРЛЭХ ЗАРИМ АРГА ЗАМ

*Л.Цэдэндамба**

1. Гадаад худалдаанд дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын нөлөөлөл, тулгамдсан асуудлууд

Манай улсын гадаад худалдааны нийт эргэлт 2000 онд 1150.3 сая ам.доллар, 2005 онд 2241.2 сая ам.доллар, 2006 онд 2977.0 сая ам.доллар, 2007 онд 4009.3 сая ам.доллар, 2008 онд 5779.0 сая ам.доллар тус тус байв. Өөрөөр хэлбэл, гадаад худалдааны нийт эргэлт 2005 онд өмнөх онтой нь харьцуулбал 16 хувиар, 2006 онд өмнөх онтой нь харьцуулбал 25 хувиар, 2007 онд өмнөх онтой нь харьцуулбал 26 хувиар тус тус өсч байв. Мөн 2004 оноос 2006 он хүртэл гадаад худалдааны тэнцэл сайжирч байсан юм. Тухайлбал, 2006 онд манай улсын гадаад худалдааны тэнцэл анх удаа 107 сая ам.долларын эерэг үзүүлэлттэй гарсан.

Гадаад худалдаанд 2008 оноос, тодорүүлбал, 2008 оны 4-р улирлаас томоохон сөрөг өөрчлөлтүүд гарч эхлэсэн байна. Гадаад худалдааны нийт эргэлт 2008 онд хэдийгээр өссөн боловч импорт үнийн дүнгээрээ ихээхэн буюу 36 хувиар өсч гадаад худалдааны тэнцэл 710.0 сая ам.долларын алдагдалтай гарсан юм.

Гадаад худалдааны нийт эргэлт 2009 оны эхний 9 сарын байдлаар 2778.1 сая ам.доллар, үүнээс экспорт 1293.8 сая ам.доллар, импорт 1484.3 сая ам.доллар болжээ. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 36.6 хувь, үүний дотор экспортын хэмжээ 33.9 хувь, импортын хэмжээ 38.8 хувиар тус тус буурчээ. Үүний зэрэгцээ 2009 оны эхний 9 сарын байдлаар экспорт, импортын зөрөө буюу төлбөрийн тэнцэл 190.5 сая ам.долларын алдагдалтай гарсан байна.

Гадаад худалдааны нийт эргэлтийн 2009 оны эхний 3 улирлын сар бүрийн үзүүлэлтүүдийг 2008 оны эхний эхний 3 улирлын сар бүрийн үзүүлэлтүүдтэй харьцуулж үзвэл 2009 оны 1-р сард 31, 2-р сард 73, 3-р сард 25, 4-р сард 42, 5-р сард 41, 6-р сард 39, 7-р сард 35, 8-р сард 31, 9-р сард 29 хувиар тус тус буурсан байна. (Зураг 1) Үүнээс үзэхэд гадаад худалдааны нийт эргэлт 2000 оноос 2008 он хүртэл тогтмол өсч ирсэн боловч 2009 онд бараг 2 дахин багасах магадлалтай байгаа юм.


* Л.Цэдэндамба - Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, профессор

Зураг 1



Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2009 оны 10 дугаар сарын 15-ны байдлаар 2936.7 сая ам.доллар, үүнээс экспорт 1369.9 сая ам.доллар, импорт 1566.8 сая ам.доллар боллоо. Гадаад худалдааны тэнцэл 2009 оны 10 дугаар сарын 15-ны байдлаар 196.9 сая ам.долларын алдагдалтай гарсан байна (Зураг 2).

Зураг 2



Өнөөгийн байдлаар нийт экспортод зэсийн баяжмал 25.5, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт 19.0, нүүрс 16.2, цайрын хүдэр, баяжмал 6.0, боловсруулаагүй нефть 5.2, төмрийн хүдэр 3.9, самнасан ноолуур тус бүр 3.7 хувь, хайлуур жоншны хүдэр, баяжмал 2.4, үлдсэн 18.1 хувийг экспортын бусад бүтээгдэхүүн эзэлж байна. (Зураг 3)

Зураг 3



Манай улсын гадаад худалдаанд яагаад дээр дурьдсан сөрөг өөрчлөлтүүд гарах болов гэсэн асуулт зүй ёсоор гарна.

Юуны өмнө 2004 оноос 2006 он хүртэл гадаад худалдааны тэнцэл сайжирч 2006 онд анх удаа 107 сая ам.долларын эерэг үзүүлэлттэй гарсан нь ямар учир шалтгаантай байсан бэ гэсэн асуулт зүй ёсоор гарна. Энэ үед буюу 2006 оны үед дэлхийн зах зээл дээр манай экспортын гол бүтээгдэхүүн болох зэс, алт, ноолуурын үнэ мэдэгдэхүйц өссөн. Үүний үр дүнд экспортын орлого нэмэгдэж, экспортын өсөлт импортын өсөлтөөс 19.4 пунктээр давж гарсан нь гадаад худалдаа 57.2 сая ам.долларын ашигтай гарахад нөлөөлсөн юм. Нэг тонн зэсийн баяжмалын дундаж үнэ 2006 онд тэр үеийн хамгийн өндөр түвшинд хүрч 2000 оныхоос 3.7 дахин, 2005 оныхоос 90.7 хувь тус тус өссөн байна. Экспортын дүнд өндөр хувийн жин эзэлдэг эрдэс бүтээгдэхүүний экспорт 2005 онтой харьцуулахад 439.2 сая ам.доллараар, нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн 55.2 сая ам.доллараар, арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс шир, ангийн үс эдгээрээр хийсэн эдлэл 14.5 сая ам.доллараар тус тус нэмэгдсэн нь экспорт өсөхөд бас голлон нөлөөлсөн. Мөн тэр үед хонь, хурганы боловсруулсан арьс буюу шевретын экспортын хэмжээ 48.9 хувь, ямаа, ишигний боловсруулсан арьс буюу шевроны экспортын хэмжээ 2.8 дахин өссөн байна. Мөн самнасан ноолуурын экспорт 54.8 хувь, бохир ноолуурын экспорт 4.7 дахин тус тус өсчээ. Эл байдал нь тэр үед гадаад худалдааны тэнцэл сайжирч 2006 онд анх удаа 107 сая ам.долларын ашигтай гарахад голлон нөлөөлсөн юм.

Гадаад худалдаанд 2008 оноос, тодорүүлбал, 2008 оны 4-р улирлаас томоохон сөрөг өөрчлөлтүүд гарч эхлэсэн юм. Дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал тэлж, хамрах хүрээ нь эрс өргөжсөн 2008 оны 11, 12-р сард зэсийн баяжмал болон зэсийг худалдан авдаг зарим оронд хэрэглээ багасч, улмаар дэлхийн зах зээлийн үнэ буурсантай холбоотойгоор манай уул уурхайн олборлох үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн борлуулалт мөн оны 9-р сартай харьцуулахад 50 орчим хувиар буурсан. Нефтийн бүтээгдэхүүн, машин, тоног төхөөрөмж, өргөн хэрэглээний зарим нэр төрлийн барааны импорт манай эдийн засагт чухал үүрэгтэй байдаг. Гэтэл 2008 онд нефтийн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ хэт өндөр, ихээхэн хэлбэлзэлтэй байв. Нефтийн бүтээгдэхүүний 2008 оны жилийн дундаж үнийг 2007 оны жилийн дундажтай харьцуулахад манай улсад 38-51 хувиар өссөн байна. Үүнтэй шууд холбоотойгоор гадаад худалдааны нийт эргэлт 2008 онд хэдийгээр өссөн боловч импорт үнийн дүнгээрээ ихээхэн буюу 36 хувиар өсч гадаад худалдааны тэнцэл 710.0 сая ам.долларын алдагдалтай гарсан юм.

Гадаад худалдааны нийт эргэлтийн хэмжээ 2009 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеийнхээс 1605.9 сая ам.доллароор буюу 36.6 хувь,

үүний дотор экспортын хэмжээ 664.9 сая ам.доллар буюу 33.9 хувь, импортын хэмжээ 941.0 сая ам.доллар буюу 38.8 хувиар тус тус буурчээ. Нийт экспортын хэмжээ буурахад дэлхийн зах зээл дэх зэсийн баяжмалын үнийн дүн 52.7 хувь, цайрын баяжмалын биет хэмжээ 12.4 хувь, үнийн дүн 47.1 хувь, боловсруулаагүй алтны биет хэмжээ 41.9 хувь, үнийн дүн нь 40.8 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Манай улсын гадаад худалдааг экспорт, импортын хүрээнд нарийвчлан авч үзвэл дараах дүгнэлтийг хийж болох юм. Үүнд:

Манай улсын экспортыг бүхэлд нь авч үзвэл дараах дүгнэлтийг хийж болох юм. Үүнд:

1. Манай улсын экспортын бүтээгдэхүүний дийлэнх хэсгийг үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос, эрдэс бүтээгдэхүүн, нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл эзэлж байна. Өөрөөр хэлбэл, боловсруулсан бэлэн бүтээгдэхүүний экспорт хэт бага, экспортын бүтээгдэхүүний нэр төрөл харьцангуй цөөн байна.

2. Экспортын өсөлтөд эрдэс түүхий эд, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн экспортын өсөлт голлох үүрэгтэй байна.

3. Экспортын бүтээгдэхүүнд болон экспортын өсөлтөд эрдэс түүхий эд, мал аж ахуйн гаралтай түүхий эд зонхилсон, түүнчлэн экспортын бүтээгдэхүүний нэр төрөл хэт цөөн байгаа нь манай улсын экспорт гадаад зах зээл дэх үнийн өөрчлөлтөөс хэт хамааралтай, улмаар гадаад худалдаа тогтвортой өсөх нөхцөл боломж бага байгааг харуулж байна.

Манай улсын импортыг бүхэлд нь авч үзвэл дараах дүгнэлтийг хийж болох юм. Үүнд:

1. Импортын бүтээгдэхүүний дийлэнх хэсгийг нефть бүтээгдэхүүн, өргөн хэрэглээний бараа, машин, тоног төхөөрөмж, тэдгээрийн сэлбэг, эд анги агаарын болон усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги, химийн болон химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн эзэлж байна. Дэлхийн жишгээр авч үзвэл энэ нь импортоос хэт хараат байгааг харуулж байгаа юм. Мөн импортын бүтээгдэхүүний нэр төрөл хэт олон байна.

2. Импортын өсөлтөд өөрийн оронд үйлдвэрлэж болох зарим бүтээгдэхүүний өсөлт нөлөөлж байна. Тухайлбал, өмнөх онтой нь харьцуулбал 2006 онд нефтийн бүтээгдэхүүний болон өргөн хэрэглээний зарим барааны импорт өссөн байна. Гэтэл манай улс түүхий нефть экспортлож байна.

3. Зарим бүтээгдэхүүний импорт, тухайлбал, нефтийн бүтээгдэхүүний импорт нэг орноос хэт хараат байна.

Манай улсын гадаад худалдааг бүхэлд нь авч үзвэл дэлхийн зах зээлийн үнийн өөрчлөлтөөс хэт хараат бөгөөд бэлэн бүтээгдэхүүнтэй харьцуулбал хэд дахин хямд үнэтэй эрдсийн болон МАА-н гаралтай түүхий эдийн экспорт давамгайлсан, импортод өөрийн оронд

үйлдвэрлэн хэрэглэж болохын зэрэгцээ гадаад зах зээлд гаргах бүрэн боломжтой олон нэр төрлийн бүтээгдэхүүн байсаар байгаа ерөнхий дүр зураг харагдаж байна. Өөрөөр хэлбэл, манай экспорт, импорт дэлхийн зах зээлд гарч болох сөрөг өөрчлөлтүүдэд хэт өртөмтгий байна. Эдгээртэй шууд холбоотойгоор улсын төсөвт, ер нь манай эдийн засагт хүндрэл бэрхшээлүүд бий болж, улмаар эдийн засаг хямрах болов. Ийм нөхцөлд экспорт, импортын бүтцийг сайжруулах, ялангуяа экспортыг дэлхийн зах зээлд гарч болох сөрөг өөрчлөлтүүдэд өртөмтгий биш болгох нь онцгой ач холбогдолтой юм. Эл байдлыг богино хугацаанд засаж залруулах магадлал бага билээ. Харин урт, дунд хугацааны эдийн засгийн хөгжлийн оновчтой зөв бодлогын хүрээнд л засч залруулах боломжтой.

2. Гадаад худалдааны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх зарим арга зам

Гадаад худалдааны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхийн тулд юуны өмнө дараах чиглэлээр эн түрүүнд анхаарч ажиллах шаардлагатай байна. Үүнд:

1. Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгагдсан Монгол Улсын экспортыг дэмжих эдийн засгийн хөгжлийн стратегийн гол агуулга нь экспортын баримжаатай уул уурхайн болон боловсруулах аж үйлдвэр, үйлчилгээний салбарыг өндөр технологид тулгуурлан эрчимтэй хөгжүүлж, эдийн засгийг олон талтай болгон, цаашдаа ашигт малтмалаас харьцангуй бага шалтгаалдаг орон болж, улмаар дэлхийн зах зээлийн үнийн өөрчлөлтөөс хэт хараат байдлыг арилгахад оршиж байгаа юм. Иймд юуны өмнө Засгийн газрын зүгээс дараах чиглэлээр ихээхэн анхаарч ажиллах шаардлагатай байна. Үүнд:

1). Экспортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг зохистой өсгөх шаардлагатай байна. Энэ зорилтын хүрээнд Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгагдсан Улаанбаатар хот, Дархан уул, Сэлэнгэ, Говьсүмбэр, Дорнод, Орхон, Ховд, Завхан аймаг, Хархоринд үйлдвэрлэл, технологийн парк, цогцолборуудыг байгуулах ажлыг яаралтай эхлүүлэх хэрэгтэй байна. Эдгээр үйлдвэрлэл, технологийн парк, цогцолборуудыг байгуулснаар юуны өмнө МАА-н гаралтай түүхий эдийг өндөр технологи хэрэглэн бүрэн боловсруулж бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн дэлхийн зах зээлд гаргаж ихээхэн ашиг олох нөхцөл бүрдэх юм. Ялангуяа хөрш зэргэлдээ БНХАУ-ын болон ОХУ-ын дэлхийд томоохонд ордог зах зээлд ийм чиглэлийн бэлэн бүтээгдэхүүний хэрэгцээ тогтмол өсч байна.

2). Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгагдсан стратегийн ач холбогдолтой Цагаан суваргын зэсийн, Таван Толгойн нүүрсний, Асгатын мөнгөний, Цавын полиметаллын, Төмөртэйн төмрийн

хүдрийн, Чойр-Нялгын нүүрс, битумын, Цайдамын хүрэн нүүрсний, Мардай, Гурванбулагийн ураны зэрэг орд газруудыг өндөр технологид тулгуурлан ашиглах ажлыг хугацаа алдалгүй эхлүүлэх шаардлагатай байна. Эдгээр ордуудыг ашиглаж эхлэснээр юуны өмнө гадаад худалдааны тэнцэл ашигтай гарч, мөнгө санхүүгийн хуримтлал бий болж, дэлхийн зах зээлийн үнийн хэлбэлзэлээс хэт хараат бус экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх таатай орчин бүрдэх болно. Жишээлбэл, оюуны багтаамжтай бага оврын бүтээгдэхүүний үйлдвэрлэлд санхүүгийн дэмжлэг үзүүлэн хөгжүүлж экспортыг нэмэгдүүлэх боломжтой болох юм.

2. Импортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг эдийн засгийн хөгжлийн хэтийн чиг хандлагатай оновчтой уялдуулан сайжруулах шаардлагатай байна. Өөрийн оронд үйлдвэрлэн хэрэглэхийн зэрэгцээ экспортод гаргаж болох зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн техник, тоног төхөөрөмжийн импортыг оновчтой дэмжих арга хэмжээ авах нь зүйтэй юм. Мөн импортын хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах шаардлагатай байна.

3. Үндэсний болон бус нутгийн, түүнчилэн салбарын хэмжээний кластеруудыг манай улсад бий болгон хөгжүүлэх нь гадаад худалдааны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх нэг гол арга зам юм. Харвардын их сургуулийн профессор Майкл Порторын дэвшүүлсэн эдийн засгийг кластерийн хандлагаар хөгжүүлэх бодлогыг АНУ, Англи, Канад, Франц, Финлянд, Швед, Өмнөд Солонгос, Японд амжилттай хэрэгжүүлж байна. Кластерийн хандлагын гол агуулга нь газар зүйн байршлын хувьд нэг дор оршдог толгой компани болон түүнийг дагасан бүтээгдэхүүн, үйлчилгээгээрээ төрөлжсөн компаниудын хамтын ажиллагааг цогц байдлаар авч үзэж оновчтой дэмжихэд оршиж байгаа юм. Кластерийн хандлагыг 3 түвшинд пирамид хэлбэрээр авч үзэн төсөөлж болох юм. Үүнийг Финляндийн Nokia компанийн туршлагаас тодорхой харж болно. Хельсинк хотод байршилтай толгой компани буюу Nokia компани нь пирамидийн дээд хэсэгт буюу эхний түвшинд үйл ажиллагаа явуулж байдаг. Хоёрдох түвшинд буюу пирамидын дунд хэсэгт толгой компани болох Nokia компанид зориулан гар утасны тодорхой хэсгүүдийг нийлүүлж байдаг мянга гаруй компани ажиллаж байдаг байна. Харин бидний төсөөлж буй пирамидийн суурь буюу доод хэсэгт толгой компанид санхүүгийн, хүний нөөцийн, дэд бүтцийн зэрэг үйлчилгээг үзүүлж байдаг олон тооны компаниуд ажиллаж байдаг байна. Ийм байдлаар хамтран ажиллан Nokia компани өрсөлдөх чадвараа сайжруулж, гар утасны үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэх компанийн нэг болсон. Өрсөлдөх чадвар султай манай компаниудын хувьд дэлхийн зах зээлд найдвартай байр суурь эзлэх гол арга зам нь энэ хандлага ч байж болох юм.

4. Дэлхийн болон бүс нутгийн нөлөө бүхий улс гүрнүүдтэй улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлэх хэрэгтэй байна. Энэ үндсэн дээр олон улсын хамтын нийгэмлэгийн хүрээнд эзлэх байр суурь, нэр хүндээ бэхжүүлэх замаар гадаад худалдааны таатай орчинг бүрдүүлж болно. Зүүн Хойд Азийн геополитик, геостратегийн орон зайд Монгол Улсын эзлэх байрыг бэхжүүлж, хоёр их хөрш ОХУ, БНХАУ-аас гадна энэ бүс нутгийн бусад оронтой идэвхтэй, найрсаг, харилцан ашигтай хамтран ажиллах нь манай гадаад худалдааг хөгжүүлэх чухал арга хэрэгсэл юм.

АШИГЛАСАН ГОЛ МАТЕРИАЛ

1. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, УИХ-ын 2008 оны 1-р сарын 31-ий өдрийн 12 тоот тогтоолоор батлагдсан. Улаанбаатар, 2008
2. Монгол Улсын статистикийн эмхэтгэл - 2006. Улаанбаатар. 2007
3. Монгол Улсын статистикийн эмхэтгэл - 2007. Улаанбаатар. 2008.
4. Л.Цэдэндамба, бусад. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын төслийн Эдийн засгийн бодлогын үндэслэл. (40 хх). УБ, 2007.
5. Л.Цэдэндамба. Монгол Улсын Үндэсний хөгжлийн хөтөлбөр боловсруулах арга зүй, аргачлал. (10 хх). Улаанбаатар 2003 он.
6. Л.Цэдэндамба. Монгол Улсад бүс нутгуудын хөгжлийн хөтөлбөр боловсруулах онолын үндэс, арга зүй, аргачлал. (20 хх). Улаанбаатар 2004 он.
7. Л.Цэдэндамба, бусад. Монгол Улсын хувийн секторын дэлгэрэнгүй судалгаа. Эрдэм шинжилгээний ажлын тайлан. УБ, 2005.
8. Л.Цэдэндамба. Монгол Улсад эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зарим арга зам. Монгол Улсын хөгжлийн судалгаа 2008 (2), хуудас 186-198. Улаанбаатар, 2008.
9. Л.Цэдэндамба. Төрийн эдийн засгийн бодлогыг боловсронгуй болгох зарим арга зам. “УТШУ-ны сургалт, судалгааны өнөөгийн байдал, хөгжлийн тулгамдсан асуудлууд” сэдэвт онол, практикийн бага хурлын илтгэлийн эмхэтгэл, Улаанбаатар, 2007
10. Development planning in Asia. Asian and Pacific Development Centre, 1993
11. Moon-Soo Kang. Korea's Economic Development. Korea Development Institute. Seoul 2003.
12. Shioya Takafusa. The Role of Development Planning in Japan. Tokio. 2004.
13. Vision 2030-Korea: A Hopeful Nation in Harmony. August 30, 2006